

## КАШМИРИЙН МӨРГӨЛДӨӨНИЙ ШАЛТГААН

Ж.Хатанхүү\*

Кашмир нь Жаму болон Кашмирийн бүс нутгийн товчилсон нэр юм. Өмнөд Азийн субконтинентийн хойд хэсгийн уулархаг нутагт байрладаг, газар нутгийн хэмжээ нь 190000 км.кв.

Дэлхийн II дайн дууссаны дараа Өмнөд Азийн субконтинент Английн колончлолоос чөлөөлөгдөж тусгаар тогтнолоо олж авсан юм. 1947 оны 6-р сарын 3-нд Англиас Энэтхэгт суугаа сүүлчийн амбан сайд Маунтбеттен Энэтхэг улсыг Энэтхэг, Пакистан гэсэн хоёр өөртөө засах доминион /Британы бүрэлдэхүүнд багтах өөртөө засах орон/ болгох “төсөл”-ийг боловсруулжээ. Уг төсөлд зааснаар Энэтхэгийн сүсэгтэн олон ихэвчлэн амьдарч байгаа нутгийг Энэтхэгт өгөх, мусульманууд олноороо суурьшиж байгаа нутгийг Пакистанд харъяалуулахаар болсон байна. Энэ төслөөр Кашмирийн газар нутаг Пакистанд хамрагдах ёстой байв. Гэвч Маунтбеттен Кашмир нь бусад газар нутагтай адилгүй гээд Исламын зөвлөл болон Жамугийн нийгэмлэгийн удирдагчид хамтран томоохон хөдөлгөөн өрнүүлж Жаму, Кашмирийг салган Энэтхэг, Пакистан гэсэн хоёр доминион улмаар тусгаар улс болгохыг Англиас шаарджээ.

Тухайн үед Кашмир нутгийн ван /махараж/ Хали Сингх тусгаар тогтнохыг хүсэж байсан учраас Энэтхэг эсхүл Пакистаны мэдэлд орох тал дээр ихээхэн алгуурлаж байв. Гэвч уг газар нутаг дээр амьдарч буй хүн амын 77% болох мусульманууд Пакистанд орж, улмаар мөн оны 9-р сарын 3-нд нутгийн ван цуст мөргөлдөөн үүсгэв. 10-р сар гэхэд мусульманы зэвсэгт хүч Кашмирийн баруун болон хойд хэсгийн томоохон газар нутгийг эзлэж 10-р сарын 24-нд чөлөөт Кашмирийн Засгийн газрыг байгуулжээ. Кашмирийн нутгийн ван аргагүйн эрхэнд 10-р сарын 26-нд Энэтхэгийн мэдэлд орсоноо зарлаж, Энэтхэгээс цэргийн туслалцаа хүсжээ. Энэтхэг, Пакистаны арми Кашмирт орсноор Энэтхэг, Пакистаны хооронд анхны дайн эхэлжээ. Сүүлд нь хоёр тал НҮБ-ын оролцоотойгоор 1949 оны 1-р сард байлдааны галаа зогсоож, 7-р сард гал зогсоосон шугамаа тогтоож,

\*Ж.Хатанхүү - Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн IY курсийн оюутан

Энэтхэг, Кашмирийн газар нутгийн 3/5, хүн амын 3/4 –ийг, Пакистан газар нутгийн 2/5, хүн амын 1/4 –ийг захирах болжээ.

1953 онд Энэтхэг Пакистан хоёр улс хэлэлцээр байгуулж, гаргасан хамтарсан мэдээндээ Кашмирийн мөргөлдөөнийг ард нийтийн санал асуулгаар шийдвэрлэнэ хэмээн мэдэгджээ. Гэвч 1964 он хүртэл Энэтхэг, Пакистаны удирдагчид төрийн тэргүүний уулзалт 4 удаа, сайд нарын хэмжээний яриа хэлэлцээ 6 удаа хийсэн ч үр дүнд хүрсэнгүй. Энэ хугацаанд Кашмирийн үндсэн хууль тогтоох Хурлаар 1956 оны 11-р сард батлагдсан үндсэн хуулиар Кашмирийг “Энэтхэгийн Холбооны улсын салшгүй хэсэг” хэмээн тунхаглажээ. 1965 оны 6-р сард Энэтхэг, Пакистаны II дайн эхлэв. Мөн оны 9-р сарын 23-нд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл тогтоол гаргаж хоёр талын байлдаан зогсжээ.

1971 онд Энэтхэг, Пакистаны хооронд Кашмирийн газар нутаг, бие даасан эрхийн талаар 3 дахь удаагийн зэвсэгт мөргөлдөөн гарав. Байлдааны гал зогссоны дараа хоёр тал Кашмирийн одоогийн мөрдөж буй заагийн шугамаа тогтоожээ. Дараа жилийнх нь 7-р сард хоёр улсын удирдагчид “Симлийн гэрээ”-г байгуулж, уг заагийн шугамыг дагаж мөрдөхөөр болжээ. 1999 оны 5-р сард Энэтхэг, Пакистан хоёр талын Кашмирийн Касурын районд гарсан зэвсэгт мөргөлдөөн нь 1971 оноос хойшхи хамгийн том хэмжээний мөргөлдөөн бөгөөд 2 сар гаруй үргэлжилж олон хүн шархдаж, амь үрэгдсэн байна.

1998 оны 5-р сард Энэтхэг, Пакистан хоёр улс дараалан цөмийн зэвсэг туршиж, цөмийн зэвсэгтэй улсуудын тоонд орсон байна. Гэхдээ цөмийн зэвсгийн туршилтууд урьд нь ч гэсэн хийгдэж байжээ. Жишээлэхэд, Энэтхэг улс бүр 1974 онд цөмийн туршилт хийж байжээ. Хэрэв цөмийн зэвсгийн дайн болбол энэ нь нэг ёсондоо сүйрэл болох юм. Саяхан ОХУ-ын БХЯ-ны сайд С.Иванов америкчуудын гаргасан тооцоог баталжээ. Хэрэв Энэтхэг, Пакистан хоёр цөмийн зэвсгийн хүчээ ашиглавал 12-17 сая хүн туяаны өвчнөөр өвчилж, нас барах юм. Гэвч юуны түрүүнд дайтаж буй хоёр орон илүү ихээр хохирол амсах нь мэдээж. Одоогийн байдлаар Энэтхэг, Пакистанаас 3-4 дахин их цөмийн зэвсэгтэй байна. 2002 оны 5-р сард хоёр орон Алма-Атад хийсэн уулзалт дээрээ цөмийн зэвсэг хэрэглэхгүй байх гэрээнд гарын үсэг зурж, дайныг түрүүлэн өдөөхгүй байх үүрэг хүлээлгэжээ.

Кашмирийн асууллын талаар дэлхий дахинд янз бүрээр хандаж байгаа. Зарим нэг нь Энэтхэгийн талд, зарим нэг нь Пакистаны талд байна. ОХУ-ын хувьд авч үзвэл, Пакистантай түүхийн олон зөрчилдөөн,

маргаантай асуудлууд байсан ба тэд Энэтхэгийг дэмжиж байв. Харин АНУ, БНХАУ “хүйтэн дайн”-ы үед Пакистаныг дэмжилгээж байв. Харин өнөөдөр ОХУ, АНУ, БНХАУ уг мөргөлдөөнийг зогсоох талаар ихээхэн хичээцгээж байна. Тухайлбал, АНУ-ын Батлан хамгаалах яамны сайд Дональд Рамсфелд Дели, Исламабад хотуудад нөхцөл байдлыг тогтворжуулахаар айлчилсан, БНХАУ-ын дарга Зян Зэминь мөн Алма-Атад айлчилж, Энэтхэг, Пакистантай хэлэлцээр хийжээ. Дашрамд дурьдахад, Хятад улс нь Пакистантай улумжлжлалт, ойр харилцаатай бөгөөд одоо Хятад, Энэтхэг хоёр улсын харилцаа тогтворжиж байна. ОХУ мөн мөргөлдөөнийг зогсоох, түүнийг дахин гаргахгүй байх тал дээр хатуу зогсож байна. Тиймээс ч өнөөдөр уг мөргөлдөөнийг улам гүнзгийрүүлэх сонирхолтой улс орон, ямарваа нэг улс төрийн үйл ажиллагаа байхгүй байна.